

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордон 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/63/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН
НОМЫН ОРДНЫ ЗАХИРАЛ
Л.МӨНХБААТАР ТАНАА

2025.02.25 № 41

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Соёлын байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, үр дүнд суурилсан 15,913.3 мянган төгрөгийг олгож, аргачлалын дагуу эрдэм шинжилгээ судалгааны ажилд 30 хувь, байгууллагын үйл ажилгааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт 40 хувь, албан хаагчдын нийгмийн баталгаанд 15 хувь, албан хаагчдын цалин урамшуулалд 15 хувийг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 524,203.6 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 40.5 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Хүүхдийн номын ордон 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 80 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 99.75 хувиар үнэлсэн байна. Мөн сар бүр Соёл урлаг, аялал жуулчлал, залуучууд хөгжлийн газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	25,938,744.33	11,761,380.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,459,044.33	
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,459,044.33	
31210	Төгрөг	16,459,044.33	
31211	Төрийн сангийн харилцах	16,459,044.33	
35	БАРАА МАТЕРИАЛ	9,479,700.00	11,761,380.00
35400	Хангамжийн материал	9,479,700.00	11,761,380.00
35410	Бичиг хэргийн материал	433,000.00	750,500.00
35420	Аж ахуйн материал	8,982,700.00	9,850,480.00
35440	Түлш, шатах тослох материал		1,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	64,000.00	160,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	563,893,121.45	589,912,734.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	563,893,121.45	589,912,734.48
39200	Биет хөрөнгө	488,817,121.45	515,136,734.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	361,416,875.31	361,416,875.31
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(54,977,354.04)	(65,972,823.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,665,000.00	15,665,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(10,443,333.12)	(13,054,166.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	49,732,120.00	92,515,455.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(18,505,995.33)	(31,505,179.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,753,737.55	36,753,737.55
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(19,353,049.84)	(24,290,175.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,925,481.54	6,925,481.54
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(2,128,296.08)	(2,514,243.56)
39217	Номын фонд	123,731,935.46	139,196,773.46
39300	Биет бус хөрөнгө	75,076,000.00	74,776,000.00
39301	Програм хангамж	2,624,300.00	2,624,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(1,424,300.00)	(1,724,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	73,876,000.00	73,876,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	589,831,865.78	601,674,114.48



5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	589,831,865.78	601,674,114.48
51	Засгийн газрын хувь оролцоо	589,831,865.78	601,674,114.48
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	315,806,105.93	315,806,105.93
511002	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	315,806,105.93	315,806,105.93
51200	Хуримтлагдсан үр дүн	(22,259,395.30)	(10,417,146.60)
51210	Өмнөх үеийн үр дүн	(33,581,986.14)	(22,259,395.30)
51220	Тайлант үеийн үр дүн	11,322,590.84	11,842,248.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	296,285,155.15	296,285,155.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	589,831,865.78	601,674,114.48



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	454,038,737.50	586,388,658.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,334,500.00	42,675,935.00
1200	Нийтлэг татварын бус орлого	20,334,500.00	42,675,935.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,334,500.00	10,636,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	7,964,500.00	10,636,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	12,370,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		32,039,935.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	433,704,237.50	543,712,723.55
1310	Улсын төсвөөс	408,312,969.50	513,249,023.55
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	408,312,969.50	513,249,023.55
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,391,268.00	30,463,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,391,268.00	30,463,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	442,716,146.66	574,546,409.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,716,146.66	574,546,409.85
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,832,454.23	556,537,473.17
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	293,726,422.06	412,577,255.88
210101	Үндсэн цалин	181,593,831.20	241,245,790.54
210102	Нэмэгдэл	50,716,481.00	104,673,101.34
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	25,917,308.50	28,008,927.00
210104	Урамшуулал	35,498,801.36	38,649,437.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,012,616.22	51,533,978.23
210201	Тэтгэврийн даатгал	25,062,521.07	34,946,752.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,997,996.74	4,111,376.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,387,217.39	2,511,178.70
210204	Ажилгүйдлийн даатгал	596,679.35	2,055,638.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,968,201.67	7,909,031.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,275,667.57	10,582,014.09
210301	Гэрэл, цахилгаан	4,558,946.36	3,681,718.13
210302	Түлш, халаалт	7,742,041.12	5,895,262.56
210303	Цэвэр, бохир ус	974,680.09	1,005,033.40
2104	Хангамж, бараа материалын зардал	7,204,125.00	8,893,075.00


2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	454,038,737.50	554,348,723.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,334,500.00	10,636,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	20,334,500.00	10,636,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,334,500.00	10,636,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	7,964,500.00	10,636,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	12,370,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	433,704,237.50	543,712,723.55
1310	Улсын төсвөөс	408,312,969.50	513,249,023.55
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	408,312,969.50	513,249,023.55
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,391,268.00	30,463,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,391,268.00	30,463,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	418,245,288.28	544,599,529.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	418,245,288.28	544,599,529.88
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376,179,483.85	524,203,593.20
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	293,726,422.06	412,577,255.88
210101	Үндсэн цалин	181,593,831.20	241,245,790.54
210102	Нэмэгдэл	50,716,481.00	104,673,101.34
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	25,917,308.50	28,008,927.00
210104	Урамшуулал	35,498,801.36	38,649,437.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,012,616.22	51,533,978.23
210201	Тэтгэврийн даатгал	25,062,521.07	34,946,752.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,997,996.74	4,111,376.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,387,217.39	2,511,178.70
210204	Ажилгүйдлийн даатгал	596,679.35	2,055,638.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,968,201.67	7,909,031.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,275,667.57	10,582,014.09
210301	Гэрэл, цахилгаан	4,558,946.36	3,681,718.13
210302	Түлш, халаалт	7,742,041.12	5,895,262.56
210303	Цэвэр, бохир ус	974,680.09	1,005,033.40
2104	Хангамж, бараа материалын зардал	4,691,600.00	7,431,105.00
210401	Бичиг хэрэг	830,500.00	1,853,660.00
210402	Тээвэр, шатахуун		1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,484,400.00	1,463,415.00
210404	Ном, хэвлэл	918,000.00	470,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00



210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,098,700.00	1,784,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,394,960.00	20,110,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		110,500.00
210604	Урсгал засвар	13,394,960.00	20,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	600,000.00	2,700,000.00
210702	Дотоод албан томилолт	600,000.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,989,390.00	11,126,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,908,050.00	8,960,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,340.00	65,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,000.00	47,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,488,828.00	8,142,730.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,488,828.00	8,142,730.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,065,804.43	20,395,936.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,045,164.00	2,387,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,430,140.00	2,387,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	36,863,052.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	751,972.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		16,745,250.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		16,745,250.77
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,640.43	1,263,685.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,640.43	1,263,685.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-I-II)	35,793,449.22	9,749,193.67
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	34,782,822.00	26,208,238.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,782,822.00	26,208,238.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	34,782,822.00	26,208,238.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	34,782,822.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,782,822.00	26,208,238.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI-IV-V)	(34,782,822.00)	(26,208,238.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	1,010,627.22	(16,459,044.33)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,448,417.11	16,459,044.33
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,459,044.33	



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	315,806,105.93	296,285,155.15	(33,581,986.14)	578,509,274.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	315,806,105.93	296,285,155.15	(33,581,986.14)	578,509,274.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ноогдол ашиг				
Тайлант үеийн үр дүн			11,322,590.84	11,322,590.84
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	315,806,105.93	296,285,155.15	(22,259,395.30)	589,831,865.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	315,806,105.93	296,285,155.15	(22,259,395.30)	589,831,865.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ноогдол ашиг				
Тайлант үеийн үр дүн			11,842,248.70	11,842,248.70
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	315,806,105.93	296,285,155.15	(10,417,146.60)	601,674,114.48



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,459,044.33		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	558,584,100.00	552,798,831.20	(5,785,268.80)	99.0
21	Урсгал зардлын дүн	558,584,100.00	552,798,831.20	(5,785,268.80)	99.0
210	Бараа үйлчилгээний зардал	556,197,100.00	550,411,831.20	(5,785,268.80)	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	412,797,100.00	412,577,255.88	(219,844.12)	99.9
210101	Үндсэн цалин	248,232,000.00	241,245,790.54	(6,986,209.46)	97.2
210102	Нэмэгдэл	115,084,500.00	104,673,101.34	(10,411,398.66)	91.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,340,000.00	28,008,927.00	10,668,927.00	161.5
210104	Урамшуулал	32,140,600.00	38,649,437.00	6,508,837.00	120.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,599,700.00	51,533,978.23	(65,721.77)	99.9
210201	Тэтгэврийн даатгал	35,087,800.00	34,946,752.93	(141,047.07)	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,128,000.00	4,111,376.94	(16,623.06)	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,064,000.00	2,511,178.70	447,178.70	121.7
210204	Ажилгүйдлийн даатгал	2,064,000.00	2,055,638.47	(8,361.53)	99.6
210205	ЭМД-ын хураамж	8,255,900.00	7,909,031.19	(346,868.81)	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,335,000.00	10,582,014.09	(4,752,985.91)	69.0
210301	Гэрэл цахилгааны зардал	4,215,000.00	3,681,718.13	(533,281.87)	87.3
210302	Түлш, халаалтын зардал	9,600,000.00	5,895,262.56	(3,704,737.44)	61.4
210303	Цэвэр бохир усны зардал	1,520,000.00	1,005,033.40	(514,966.60)	66.1
2104	Хангамж, бараа материалын зардал	12,060,000.00	12,059,943.00	(57.00)	100.0
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,853,660.00	53,660.00	103.0
210402	Тээвэр шатахуун	1,800,000.00	1,500,000.00	(300,000.00)	83.3
210403	Шуудан холбоо	900,000.00	1,463,415.00	563,415.00	162.6
210404	Ном	5,400,000.00	5,098,838.00	(301,162.00)	94.4
210405	Хог хаягдал	360,000.00	360,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,800,000.00	1,784,030.00	(15,970.00)	99.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,165,300.00	31,165,300.00		100.0



210601	Багаж хэрэгсэл	11,165,300.00	11,165,300.00	-	100.0
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	2,700,000.00	-	100.0
210702	Дотоод томилолт	2,700,000.00	2,700,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	21,940,000.00	21,226,010.00	(713,990.00)	96.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	19,774,000.00	19,060,670.00	(713,330.00)	96.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	66,000.00	65,340.00	(660.00)	99.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,000.00	47,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	-	100.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,420,000.00	1,420,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,600,000.00	8,567,330.00	(32,670.00)	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,600,000.00	8,567,330.00	(32,670.00)	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,387,000.00	2,387,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,387,000.00	2,387,000.00	-	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,387,000.00	2,387,000.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	558,584,100.00	554,348,723.55	(4,235,376.45)	99.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	513,249,100.00	513,249,023.55	(76.45)	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	513,249,100.00	513,249,023.55	(76.45)	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,335,000.00	30,463,700.00	(2,871,300.00)	91.4
132001	Орон нутгийн төсвөөс	33,335,000.00	30,463,700.00	(2,871,300.00)	91.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,000,000.00	10,636,000.00	(1,364,000.00)	88.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	10,636,000.00	(1,364,000.00)	88.6
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	17.00	-	100.0



Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордон нь Ерөнхий боловсролын сурагчдад ном уншуулах сургалт явуулах үйл ажиллагааг явуулж, уншигчдад ая тухтай орчинд хичээлээ давтах, ном хэвлэл унших, өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, бүх насныханд үйлчилдэг байнгын үйл ажиллагаатай уншлага үйлчилгээний 2 танхим, салбар номын сан 1, төрөлжсөн 5 танхимтай, нэг ээлжид 175 уншигч хүлээн авах хүчин чадалтай номын сангийн үйлчилгээг үзүүлж байна.

Төрөлжсөн танхимууд:

- Байгалийн ухаан-Математикийн танхим
- Монгол хэл-бичиг, уран зохиол танхим
- Англи хэлний танхим
- Компьютер, мэдээлэл технологи /чөлөөт уншлагын танхим/
- “Book and Coffee” танхим /чөлөөт уншлагын танхим/

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Журам батлах тухай”, 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, 2022 оны 192 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”, Соёлын сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн а/238 тушаал “Аргачлал батлах тухай” зэрэг хууль эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Хүүхдийн номын ордон 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам"-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Хүүхдийн номын ордон 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,842.3 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,459.00	-	(16,459.00)
Авлага	-	-	-
Бараа материал	9,479.70	11,761.40	2,281.70
Үндсэн хөрөнгө	563,893.10	589,912.70	26,019.60
Нийт хөрөнгө	589,831.80	601,674.10	11,842.30
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	589,831.80	601,674.10	11,842.30
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	589,831.80	601,674.10	11,842.30

Бараа материалын дансны үлдэгдэл 11,761.4 мянган төгрөг болж 2,281.7 мянган төгрөгөөр өссөн нь Соёлын сайдын А/390, А391 дугаар тоот тушаалаар үр дүнд суурилсан санхүүжилтээр 33,201.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, тайлант онд

30,920.1 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 9,850.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 750,5 мянган төгрөгийн бичиг хэрэг, шатах тослох материал 1,000.0 төгрөгийн материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 589,912.7 мянган төгрөг болж 26,019.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11,178.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 15,029.8 мянган төгрөгийн ном худалдан авч, Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01-А/99 тоот захирамжаар 2,835.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 28,769.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 435,0 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй авч тайлант онд 32,228.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 601,674.1 мянган төгрөг болж 11,842.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 374,585.4 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 513,249.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг байгууллагын үнэлгээгээр олгосон байна.

Тайлант онд төсвийн төслөөс 138,663.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь цалин хөлс нэмэгдсэн, мөн гүйцэтгэлд суурилсан нэмэлт санхүүжилт олгосонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 513,249.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,463.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,636.0 мянган төгрөг нийт 554,348.7 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 30,463.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 39,200.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 1,263.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс 513,249.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 512,962.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн буюу өмнөх оны үлдэгдэл 16,745.2 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 552,798.83 төгрөг буюу 99,0 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 18,008.9 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг	558,584.10	552,798.83	(5,785.27)	98,28%

1.1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	487,335.80	484,180.03	(3,155.77)	100%
1.2	80111-Төрийн өмчийн байрилгын тогтмол зардал	33,335.00	32,071.30	(1,263.70)	91,39%
1.3	80215-Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,000.00	10,000.00	-	100%
1.4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	-	-	-	0%
1.5	81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	15,913.30	15,911.50	(1.80)	100%
1.6	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан /үндсэн үйл ажиллагааны орлого/	12,000.00	10,636.00	(1,364.00)	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын Хүүхдийн номын ордны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 442,716.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,427.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2024 оны төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цалингийн зардлыг 219.8 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 65.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус номын ордны 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 1,441.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	1,441.5	1	1,441.5	100
Нийт дүн	1	1,441.5	1	1,441.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тус тус зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Тус номын ордны Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-					1	-